



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар A/190

Булган сум

### Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Аймгийн нөөцийн тэжээлийн агуулахын засвар, тохижилт (Булган сум) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “СЭМЭ” ХХК-тай 29,100,000 (Хорин есөн сая нэг зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ны захирал (Б.Одхүү)-д олгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “СЭМЭ” ХХК-ийн захирал (С.Хишигбаатар)-д үүрэг болгосугай.

3. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын 29-ны өдрийн А/190 дугаар  
захирамжийн хавсралт

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Одхүү
3	Магадлашгүй ажил	-	Б.Одхүү
4	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	-	Б.Одхүү
5	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	-	Б.Одхүү
6	Нормчлолын сан	-	Б.Одхүү
7	Захиалагчийн албаны зардал	-	Б.Одхүү